

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ХООРОНДЫН УЯЛДААНД ҮНЭЛГЭЭ ХИЙХ, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаанд үнэлгээ (цаашид “үнэлгээ” гэх) хийх, бодлогын зорилтуудын тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход энэхүү аргачлалыг баримтлана.
- 1.2. Үнэлгээ хийх ажлын зорилго нь хөгжлийн бодлогын нэгдмэл, цогц байдлыг хангах үүднээс бодлогын баримт бичгүүдийн босоо болон хэвтээ чиглэлийн уялдааг үнэлэх, шаардлагатай тохиолдолд нийцүүлэх арга хэмжээ авах, шинээр боловсруулж буй бодлогын баримт бичгийн уялдааг хангахад оршино.
- 1.3. Бодлогын зорилтуудын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлын зорилго нь тухайн чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлэх, урт хугацаанд асуудлыг шийдвэрлэхэд хамгийн их нөлөөлөл үзүүлэх зорилтыг тодорхойлоход оршино.
- 1.4. “Хөгжлийн бодлогын баримт бичиг” гэж Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.3-6.5 дахь хэсэгт заасныг болон Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэлнэ.
- 1.5. “Бодлогын зорилт” гэж Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын 9.4 дэх хэсэгт заасныг хэлнэ.

Хоёр. Үнэлгээ хийх

- 2.1. Үнэлгээг дараах ерөнхий 2 үе шаттайгаар хийнэ:
 - 2.1.1. Хөгжлийн бодлогын уялдааг шалгах, нэг баримт бичигт туссан бодлого нөгөө баримт бичигт тусгагдсан эсэхийг үнэлэхдээ матрицын аргыг ашиглана.

Бодлогын баримт бичиг 1	Бодлогын баримт бичиг 2	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй, 4-манай оронд хамааралгүй (Зөвхөн Дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтууд /цаашид ДТХЗ гэх/ болон Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030 /цаашид МУТХҮБ-2030 гэх/-ын уялдааг үнэлэхэд ашиглана)
Зорилт 1	Хамаарах зорилт	Дээрх 4 ангилалын аль тохирох тоон тэмдэглэгээг тавина.
Зорилт 2		
Зорилт ...		

Хүснэгтийн гуравдугаар баганад тоон ангиллыг тавихдаа шууд тусгагдсан гэдэг үнэлгээг бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан бодлогын зорилтын агуулга яг давхцаж байгаа тохиолдолд, агуулгын хувьд уялдсан гэдэгт зорилтын агуулгын зарим хэсгүүд тусгагдсан, эсвэл арай өөр хэлбэрээр илэрхийлсэн боловч агуулгын хувьд нийцсэн тохиолдолд хэрэглэнэ.

2.1.2. Хөгжлийн бодлогын зорилтуудыг хэрэгжүүлснээр бодлогын бусад зорилтуудад хэрхэн нөлөөлөхийг үнэлэх. Бодлогын нөлөөллийг үнэлэхдээ энгийн харилцан нөлөөлийн матриц (gross-impact matrix)-ыг ашиглана.

Зорилтууд		Үр дүнгийн хувьсагч			ДҮН
		Зорилт-1	Зорилт-2	Зорилт-3	
Нөлөөлөгч хүчин зүйл	Зорилт-1				
	Зорилт-2				
	Зорилт-3				

Сонгосон бодлогын зорилтуудыг матрицдаа байрлуулахдаа мөрүүдэд нь нөлөөлөгч хүчин зүйлд хамаарах зорилтоо, харин багананд нь түүнээс хамаарах нөлөөллийн үр дүнг нь сонирхож байгаа зорилтуудаа байрлуулна. Мөрд бичигдсэн зорилтын хэрэгжүүлт нь багананд бичигдсэн зорилтын хэрэгжилтэд ямар нөлөө үзүүлэхийг дараах 7 түвшинтэй оноогоор үнэлнэ.

- Харьцуулж буйн зорилтын хэрэгжилтэнд шууд хүчтэй нөлөөтэй, шууд хүчтэй уялдаатай бол +3 оноо
- Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд тус болох бол +2 оноо
- Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх нөхцлийг яваандаа бүрдүүлэх бол +1 оноо
- Эерэг болон сөрөг ямар нэг нөлөө үзүүлэхгүй бол 0 оноо
- Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх сонголтуудыг хязгаарлах бол -1 оноо
- Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх бол -2 оноо
- Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болгоно, хүчтэй эсрэг нөлөөтэй бол -3 оноогоор тус тус үнэлнэ.

Нөлөөллийг дүгнэсний дараа үр дүнг мөр бүрээр нэгтгэн сүүлийн багананд гаргах ба үнэлгээг хийхдээ онооны боломжит дээд хэмжээнд эзлэх хувийг тооцож, доорх 5 бүлэгт ангилна. Үүнд:

- 20 хүртэлх хувьтай бол хамааралгүй, нөлөө маш багатай
- 21-40% бол сулхан нөлөөтэй
- 41-60% бол дунд зэргийн нөлөөтэй
- 61-80% бол дундаас дээгүүр нөлөөтэй,
- 81-100% бол хүчтэй хамаарал, нөлөөтэй

2.2. Үнэлгээг дараах дөрвөн чиглэлийн хүрээнд хийнэ:

2.2.1. **Чиглэл нэг:** ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын зорилтуудын уялдааг үнэлэх. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын зорилтууд МУТХҮЗ-2030-д хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлэх арга зүйг дараах үе шаттайгаар хэрэглэнэ.

2.2.1.1. ДТХЗ-д тодорхойлсон бодлогын зорилтууд МУТХҮЗ-2030-д хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлэхдээ доорх хүснэгтийг ашиглана.

Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтууд (ДТХЗ)	Монгол Улсын ТХҮЗ-2030	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй, 4-манай оронд хамааралгүй
Доош нь 17 зорилгын	Монгол Улсын 44	Дээрх 4 ангилалын аль

хүрээнд 169 зорилтуудыг нэг бүрчлэн харуулна.	зорилтуудаас гадна зарчим хэсэгт орсон хэс-гүүдээс холбогдох байдлаар нь зэрэгцүүлэн харуулна.	тохирох тоон тэмдэглэгээг тавина.
---	--	-----------------------------------

Ангилал бүрээр үнэлэгдсэн зорилтуудын нийлбэрийг гарган нийт зорилтуудад эзлэх хувийг тооцсоноор ДТХЗ-ууд МУТХҮБ-2030-д тусгагдсан байдалд дүгнэлт өгнө.

- 2.2.1.2. ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын зорилтууд хоорондоо хэрхэн уялдсан, харилцан нөлөөлөх байдлыг үнэлэх арга зүйг дараах байдлаар хэрэглэнэ. Нөлөөллийг үнэлэхдээ харилцан нөлөөллийн матрицыг ашиглан энэхүү журмын 2.1.2 дахь заалтад заасан онооны дагуу оноожуулна.

МУТХҮБ-2030	ДТХЗ						Дүн	Онооны үнэлгээ, %
	1.1	1.2	1.3	1.4	1.5	...		
Зорилт 1								
Зорилт 2								
Зорилт 3								
...								
Дүн								

Мөр тус бүрээр онооны боломжит дээд хэмжээнд эзлэх хувийг тооцож, МУТХҮБ-2030-ын зорилтууд ДТХЗ-уудын хэрэгжилтэд нөлөөлөх байдалд 2.1.2 дахь хэсэгт заасны дагуу дүгнэлт өгнө.

- 2.2.2. **Чиглэл хоёр:** ДТХЗ, МУТХҮБ-2030 болон салбар, орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдааг үнэлэх. ДТХЗ болон МУТХҮБ-2030 –д тодорхойлсон бодлогын зорилтууд салбарын хөгжлийн бодлогод хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгөх арга зүйг дараах дараах үе шаттайгаар хэрэглэнэ.

- 2.2.2.1. ДТХЗ болон МУТХҮБ-2030 –д тодорхойлсон бодлогын зорилтууд салбарын хөгжлийн бодлогод хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлгээ өгөхдөө доорх хүснэгтийг ашиглана.

ДТХЗ, МУТХҮБ-2030	Салбарыг хөгжлийн асуудлаар төрөөс баримтлах бодлого	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй
ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын зорилтуудаас гадна зарчим хэсэгт орсон хэсгүүдээс холбогдох байдлаар нь зэрэгцүүлэн харуулна.	Салбарын бодлогын баримт бичигт ДТХЗ, МУТХҮБ-2030-д холбогдох зорилт, заалт байвал бичнэ.	Дээрх 3 ангилалын аль тохирох тоон тэмдэглэгээг тавина.

Тухайн салбар хүчинтэй үйлчилж буй хэд хэдэн бодлогын баримт бичигтэй бол матрицын баганын тоог нэмнэ. Ангилал бүрээр үнэлэгдсэн зорилтуудын нийлбэрийг гарган нийт зорилтуудад эзлэх хувийг тооцсоноор салбарын бодлогын баримт бичиг ДТХЗ болон МУТХҮБ-2030-д тусгагдсан байдалд дүгнэлт өгнө.

- 2.2.2.2. ДТХЗ болон МУТХҮЗ-2030-ын зорилтууд салбарын хөгжлийн бодлоготой хэрхэн уялдсан байдлыг үнэлэх арга зүйг дараах байдлаар хэрэглэнэ. Нөлөөллийг үнэлэхдээ харилцан нөлөөллийн матрицыг ашиглан энэхүү журмын 2.1.2 дахь заалтад заасан онооны дагуу оноожуулна.

Салбарын бодлогын зорилтууд	ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын зорилтууд							Онооны үнэлгээ, %
	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт ..	Дүн	
1								
2								
3								
...								
Дүн								

Матрицын сүүлийн баганад гарах дүн нь тухайн мөрөнд тусгасан салбарын бодлогын баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлснээр ДТХЗ болон МУТХҮБ-2030-ыг хэрэгжүүлэхэд хэр нөлөө үзүүлэхийг харуулна.

Энэхүү хүснэгтийн мөр, багана дахь зорилтуудыг солин тавьснаар ДТХЗ болон МУТХҮБ-2030-ын зорилтууд нь салбарын хөгжлийн зорилтуудад үзүүлэх нөлөөллийг үнэлэх боломжтой.

- 2.2.3. **Чиглэл гурав:** Нэг салбарын дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа, залгамж чанарыг үнэлэх. Нэг салбарын хэд хэдэн бодлогын баримт бичгүүд хоорондоо хэрхэн уялдсан, өөр цаг хугацаанд батлагдсан салбарын бодлогын баримт бичгүүдийн залгамж чанар хадгадагдсан эсэхийг шалгахад арга зүйг дараах дараах үе шаттайгаар хэрэглэнэ.

- 2.2.3.1. Салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хоорондын уялдаа, бодлогын гол зорилтууд залгамж чанартайгаар тусгагдсан байдлыг үнэлэхэд доорх хүснэгтийг ашиглана.

Салбарын БББ 1	Салбарын БББ 2	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй	Салбарын БББ 3	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан, 3-огт тусгагдаагүй
Бодлогын гол зорилтууд	Холбогдох зорилт, заалт байвал бичнэ.		Холбогдох зорилт, заалт байвал бичнэ.	

Ангилал бүрээр үнэлэгдсэн зорилтуудын нийлбэрийг гарган нийт зорилтуудад эзлэх хувийг тооцсоноор салбарын бодлогын баримт бичиг хоорондын уялдаанд дүгнэлт өгнө.

- 2.2.3.2. Салбарын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн өөр хоорондын уялдаа, харилцан нөлөөллийг үнэлэх арга зүйг дараах байдлаар хэрэглэнэ. Нөлөөллийг үнэлэхдээ харилцан нөлөөллийн матрицыг ашиглан энэхүү журмын 2.1.2 дахь заалтад заасан онооны дагуу оноожуулна.

Салбарын БББ 1-ийн зорилтууд	Салбарын БББ 2-ын зорилтууд							Онооны үнэлгээ, %
	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт ..	Дүн	
1								
2								
3								
...								
Дүн								

Матрицын сүүлийн баганад гарах дүн нь тухайн мөрөнд тусгасан салбарын бодлогын баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлснээр баганад тусгасан салбарын бодлогын баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлэхэд хэр нөлөө үзүүлэхийг харуулна.

- 2.2.4. **Чиглэл дөрөв:** Үндэсний болон салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтууд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөө, яам, агентлагуудын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги, төлөвлөгөөнүүдэд хэрхэн тусгагдсаныг шалгаж, үнэлэх арга зүйг дараах дараах үе шаттайгаар хэрэглэнэ.

- 2.2.4.1. МУТХҮБ-2030 болон салбарын хөгжлийн бодлогын зорилтууд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон салбарын дунд хугацааны төлөвлөгөөнд тусгагдсаныг үнэлэхэд доорх хүснэгтийг ашиглана.

МУТХҮБ-2030 болон салбарын хөгжлийн бодлого	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон салбарын дунд хугацааны төлөвлөгөө	1-шууд тусгагдсан, 2-агуулгын хувьд уялдсан 3-огт тусгагдаагүй
МУТХҮБ-2030-ын 44 зорилтуудаас гадна зарчим хэсэгт орсон хэсгүүдээс холбогдох байдлаар нь зэрэгцүүлэн харуулна.	Холбогдох зорилт, заалт байвал бичнэ.	Дээрх ангилалын аль тохирохоор үнэлнэ.

Ангилал бүрээр үнэлэгдсэн зорилтуудын нийлбэрийг гарган нийт зорилтуудад эзлэх хувийг тооцсоноор дүгнэлт өгнө.

- 2.2.4.2. Салбарын хөгжлийн бодлогын зорилтууд болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн харилцан нөлөөллийг үнэлэх арга зүйг дараах байдлаар хэрэглэнэ.
Нөлөөллийг үнэлэхдээ харилцан нөлөөллийн матрицыг ашиглан энэхүү журмын 2.1.2 дахь заалтад заасан онооны дагуу оноожуулна.

ЗГҮАХ тусгагдсан үйл ажиллагаа	Салбарын талаар төрөөс баримтлах бодлого							Онооны үнэлгээ, %
	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт ..	Дүн	
1								
2								
3								
...								
Дүн								

Матрицын сүүлийн баганад гарах дүн нь тухайн мөрөнд тусгасан ЗГҮАХ-ийг хэрэгжүүлснээр баганад тусгасан салбарын бодлогын баримт бичгийн зорилтыг хэрэгжүүлэхэд хэр нөлөө үзүүлэхийг харуулна.

Энэхүү хүснэгтийн мөр, багана дахь зорилтуудыг солин тавьснаар салбарын бодлогын баримт бичгийн зорилтууд ЗГҮАХ-т тусгагдсан үйл ажиллагааны хэрэгжилтэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх боломжтой.

Гурав. Хөгжлийн тэргүүлэх чиглэл тодорхойлох

Хөгжлийн тэргүүлэх чиглэлийг дараах хоёр арга зүйн ерөнхий зарчмаар тодорхойлно.

- 3.1. Дээрээс доош төлөвлөх арга. Дээрээс доош төлөвлөх аргаар дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлохдоо урт хугацааны бодлогод тусгагдсан алсын харааг сайтар харгалзан үзэж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлно. Энд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн үе шат бүр нь дараагийнхаа үе шаттай уялдсан, түүнд чиглэсэн байх логик уялдаатай байна.

Алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэсэн дунд хугацааны хөгжлийн бодлого нь 2 түвшинд тодорхойлогдоно. Үүнд:

- Макро түвшний бодлогууд
- Салбарын хөгжлийн бодлогууд

- 3.2. Доороос дээш төлөвлөх аргаар зарчмаар дунд хугацааны хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлохдоо дараах 2 чиглэлээр гүйцэтгэнэ.

3.2.1. Салбарын хөгжлийн бодлогод тодорхойлсон дунд хугацааны бодлогын зорилтуудыг МУТХҮБ-2030-ын зорилтуудын хэрэгжилтэд үзүүлэх нөлөөг энэхүү аргачлалын 2.2.2.2 дахь хэсэгт харуулсан хүснэгтийн дагуу үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүнд МУТХҮБ-2030-ын зорилтуудын хэрэгжилтэд эерэг хүчтэй нөлөө үзүүлэхээр гарсан зорилтуудыг тэргүүлэх чиглэлийн хүрээнд авч үзнэ.

3.2.2. Доороос дээш төлөвлөх аргын дараагийн шатанд оролцооны аргаар тэргүүлэх чиглэлийг тодорхойлох бөгөөд дараах үе шаттай хийгдэнэ.

- 3.2.2.1. Оролцооны аргаар салбарын өмнө тулгамдсан шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлно.
- 3.2.2.2. Тодорхойлсон тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх бодлогын зорилтууд болгон хувиргаж, томъёолно.
- 3.2.2.3. Томъёолсон зорилтуудын ач холбогдол, хэрэгжүүлэх шаардлагатхй хугацааг харгалзан дэс дарааг тодорхойлоход дараах хүснэгтийг ашиглаж болно.

	Яаралтай	Яаралтай биш
Чухал	ЯГ ОДОО ХИЙ	ХЭЗЭЭ ЯАЖ ХИЙХ СТРАТЕГИ ЦАГ ХУГАЦААГАА ГАРГА
Чухал биш	БУСДАД ДААТГА: хийж чадах хүнээ олох	ОГТ ХЭРЭГГҮЙ, УСТГА

	Богино хугацаа	Урт хугацаа
Ач холбогдол бага	Шаардлагагүй	Шаардлагагүй
Ач холбогдол өндөр	Шууд хэрэгжүүл	Хэзээ яаж хэрэгжүүлэхээ тодорхойл

	Өндөр үр нөлөө	Бага үр нөлөө
Өндөр өртөг	Хэзээ яаж хэрэгжүүлэхээ тодорхойл	Огт хэрэггүй
Бага өртөг	Шууд хэрэгжүүл	Шаардлагагүй

- 3.2.2.4. Томъёолсон зорилтуудын харилцан нөлөөллийг энэхүү аргачлалын 2.1.2 дахь хэсэгт заасан энгийн харилцан нөлөөллийн матриц ашиглан үнэлнэ. Үнэлгээний дүнд бусад зорилтууддаа хамгийн их эерэг нөлөөлөл үзүүлэхээр гарсан зорилт/ууд/-ыг тэргүүлэх чиглэл болгон сонгон авна.